



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР**

2022 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 01

Ховд

**Сургууль төгсөлтийн үйл ажиллагааг  
зохион байгуулах тухай**

Оюутан, сурагчдын төгсөлтийн үйл ажиллагааг “Эрдмийн баяр” болгон тэмдэглэн өнгөрүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалтыг үндэслэн ДААЛГАХ нь:

Нэг. Боловсрол, шинжлэх ухааны газар, сумдын Засаг дарга нар, Ховд Их Сургууль, “Хөгжил” политехник коллеж, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт:

1. “Эрдмийн баяр”-ыг тэмдэглэхдээ сурсан мэдсэн, хийсэн бүтээснээ тайлагнах тайлант өдөрлөг болгон нэгдсэн удирдлага, зохион байгуулалттайгаар сум, сургууль бүр нэг өдөр зохион байгуулах

2. Оюутан, суралцагчаас хуульд заагаагүй аливаа төлбөр, хураамж, хандив авахыг хориглох

3. Анги дэвших болон улсын шалгалт, элсэлтийн ерөнхий шалгалттай холбоотойгоор хичээл заадаг багш тухайн ордог хичээлээрээ суралцагчдад төлбөртэй давтлага өгөх, ном, гарын авлага, материал худалдан авахыг шаардах, шахахыг хориглох

4. Оюутны болон сурагчдын зөвлөл, эцэг эхийн зөвлөлийн үүсгэл санаачлага нэрээр мөнгө татаж, багшид бэлэг өгөх, эцэг эхэд санхүүгийн дарамт учруулахыг таслан зогсоох, эцэг эхчүүдийн оролцоо хяналтыг сайжруулах

5. Ховд Их Сургууль, “Хөгжил” политехник коллеж, ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчид хөдөө хээр, амралт зуслан, голын сав, жуулчны бааз, зочид буудал, цэнгээний газруудад амралт, зугаалга зохион байгуулах, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох


6. Сум, багийн Засаг дарга, аймгийн Цагдаагийн газар, хэсгийн байцаагч нарт “Эрдмийн баяр”-ыг тэмдэглэх мэдээлэл хүргүүлж, аливаа учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах

7. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжиж байгаа “Тэрбум мод” хөтөлбөрийг дэмжиж сургууль бүр ногоон орчин байгуулж, төгсөгчдийн нэрэмжит төгөл бий болгох, хийсэн ажлаа олон нийтэд таниулж, бусаддаа бүтээлч, зөв үлгэр дуурайлал үзүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах

8. Сургуулийн захиргаа, анги удирдсан багш нар төгсөх ангийн оюутан, сурагчдад гэмт хэрэгт холбогдох, хэв журмын болон ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ярилцлага, уулзалт зохион байгуулах

Хоёр. Албан даалгаврын хэрэгжилтийн дүнг 2022 оны 06 дугаар сард багтаан танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (Б.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

Гурав. “Эрдмийн баяр”-ын үеэр хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг Цагдаагийн газрын дарга (Д.Мөнхболд)-д, албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д тус тус даалгасугай.

ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ

